

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦСОН НАМ, ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН
ЗАРДЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ӨВА-2020/04/-НА/

Арвайхээр хот
2020 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг:

Аудитын менежер Д.Гансүх, Утас: 70323833,
цахим хаяг: Gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Ө.Ринчинмядаг, Утас: 70323108,
цахим хаяг: Renchinmyadagu@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр, Утас: 70323108,
цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аудитын нэр

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан баталгаажуулах.

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасныг үндэслэн Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг хянаж баталгаажуулсан.

Аудитын зорилго

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

Аудитын хамрах хүрээ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамарсан.

Арга зүй

Аудитын ажлыг гүйцэтгэхэд Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Үндсэн мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн 39 тойрогт 4 намаас 977 иргэн нэр дэвшсэн байна. Үүнд:

- Монгол Ардын нам 488
- Ардчилсан нам 483
- Монгол Ардын хувьсгалт нам 5
- Үнэн ба Зөв нам 1

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс сонгуулийн зардлын тайлангаа 2 нам ирүүлсэн бөгөөд Монгол Ардын нам зардлын хураангуй тайлангаар нийт 244.3 сая төгрөгийн орлого, 243.0 сая төгрөгийн сонгуулийн үйл ажиллагааны зардал тайлагнаж, харилцах дансны үлдэгдэл 1.3 сая төгрөг, Ардчилсан Нам зардлын хураангуй тайлангаараа 30.1 сая төгрөгийн орлого, 26.4 сая төгрөгийн сонгуулийн үйл ажиллагааны зардалтай холбоотой зардал гарч 3.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сонгуульд оролцсон нам, эвсэлд 1 хуулийн этгээд 5.0 сая төгрөг, 8 иргэн 7.8 сая төгрөг, нийт 12.8 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн байна.

Нам, эвсэл сонгуулийн зардлын тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Сурталчилгаанд оролцсон иргэдэд урамшуулал олгохдоо хуулийн дагуу гэрээ хийсэн боловч сурталчилгааны материал хэвлүүлсэн, шатахуун худалдаж авсан байгууллагуудын анхан шатны баримт дутуу, баримтын бүрдэл хангалтгүйгээс 4.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Ардчилсан намын 20 хорооны сонгуулийн зардлын тайланд аудит хийхээс 7 хорооны тайланд аудит хийж дүгнэлт гаргасан бусад 13 хороо нь зардлын тайлан холбогдох баримт, материалаа ирүүлээгүйгээс дүгнэлт гаргаагүй байна.

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/09 дугаар тушаалаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох аймгийн намын зардлыг 305.5 сая төгрөгөөр тогтоосон, сумын намын зардлын дээд хэмжээг 18.8-44.4 сая төгрөгөөр тогтоосон ба сонгуульд оролцсон намууд тогтоосон хэмжээнд зардал гаргасан байна.

Сонгуулийн зардлын дансны орлого, зардал

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан хугацаандаа ирүүлсэн 2, тайлангаа ирүүлээгүй 2 нам байна.

Нам, эвслийн сонгуулийн зардлын тайлангаарх нийт орлого 12.8 сая төгрөгийг орлогын ангиллаар харуулбал. Үүнд:

Хүснэгт-1 Намын орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Орлого				Нийт	
	Тоо	Мөнгөн	Тоо	Мөнгөн бус	Тоо	Дүн
Нам, эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	-	-	-	-	-	-
Хуулийн этгээдийн хандив	1	5.0	-	-	1	5.0
Иргэний хандив	8	7.8			8	7.8
Дүн	9	12.8			9	12.8

Нам, эвсэл сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 12.68 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 12.68 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт-2 Намын зарцуулалт /сая төгрөг/

Зардлын ангилал		Мөнгөн дүн
Нийт зардлын дүн		12.68
2.1	Сонгуулийн зардлын дүн	12.68
2.1.1	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	7.58
2.1.2	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах	
2.1.3	намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	
2.1.4	сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	
2.1.5	сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	5.1
2.1.6	сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал	
2.1.7	цахим орчин ашиглах зардал	
2.1.8	өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	
2.2.	Бусад зардлын дүн	

Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/16 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ын дагуу аудит хийж баталгаажуулсан тайланг аймгийн Төрийн аудитын газар дахин хянаж баталгаажуулсан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д "Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу нам, эвслийн зардлын дансны хуулгыг ирүүлсэн байна.

Аудитын дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон 4 намаас Монгол Ардын нам, Ардчилсан намууд сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн, харин Монгол Ардын хувьсгалт нам, Үнэн Ба Зөв нам сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
УЧОА0059 9844094